



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 12 өдөр

Дугаар А/592

Есөнбулаг

Үнэлгээний хороо байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1.Засгийн газрын 2023 оны 279 дүгээр тогтоолын дагуу гамшгийн сангийн хөрөнгөөр аймгийн аюулгүй нөөцөд тэжээл бэлтгэх ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Г.Болдбаатар (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
П.Хулан (аймгийн Засаг даргын туслах)
Ё.Нарангарав (Хөндлөнгийн төлөөлөл)
(тохиролцсоноор)
С.Саруулсайхан (Есөнбулаг сумын иргэн)
Нарийн бичгийн дарга: Б.Эрхбаяр (Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн)

2.Тендерийн баримт бичгийг боловсруулан гаргаж, худалдан авах ажиллагааг хугацаа алдалгүй чанартай зохион байгуулан, дүнг хуулийн хугацаанд танилцуулахыг Үнэлгээний хороо (Г.Болдбаатар)-нд үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ

